ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/030/НА-СТА-ТШЗ

## ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ГУРАВДУГААР СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн захирал Д.Энхбаатар
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tov@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2021.02.25 № 01/218

танай ____________-ны № ________________-т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ГУРАВДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,182,449.3 мянган төгрөгийн, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Татан буугдсан 5 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 187,067.0 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд татан төвлөрүүлээгүй;
- Авлагын дансанд Есөн хэлхээ ХХК-иас авах 550.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирлын 2025 оны А/12 дугаар тушаал "Өмч хүлээн авах, хамгаалах ажлын хэсэг байгуулах тухай"-аар 9 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилж хөрөнгийн тооллого хийхэд нийт 16,480.2 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан, үр дүнг тайланд тусгаагүй;

- Татан буугдсан 5 дугаар сургуулийн НДШ-ийн авлага 1,484.7 мянган төгрөгийг тайлагнаагүй

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 70 дугаар зүйлийн 70.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх", "Үнэн ба зөв байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус сургууль нь Төв аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн "Зуунмод сумын сургуулиудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх тухай" А/446 дугаар захирамжаар Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, үйл ажиллагаа менежментийг сайжруулах зорилгоор бүтцийн өөрчлөлтийг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр Спортын төрөлжсөн сургууль болон Зуунмод сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийг нэгтгэн, Зуунмод сумын гуравдугаар бүрэн дунд сургууль болгон өөрчилж 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "Бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын гуравдугаар сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 45 арга хэмжээн хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 92.0%-тай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний Үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **326,744,634.07** | **1,046,142,913.81** |
| **31** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **4** | **282,483,417.73** | **853,489,444.78** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | | **282,483,417.73** | **853,489,444.78** |
| **3121** | **Төгрөг** | | **282,483,417.73** | **853,489,444.78** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 282,483,417.73 | 853,489,444.78 |
| **33** | **АВЛАГА** | **5** | **722,736.34** | **605,507.37** |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | | 172,736.34 | 55,507.37 |
| **335** | **Бусад авлага** | | **550,000.00** | **550,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | | 550,000.00 | 550,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | **43,538,480.00** | **192,047,961.66** |
| **354** | **Хангамжийн материал** | | **43,538,480.00** | **192,047,961.66** |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 651,000.00 | 8,067,269.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 3,261,280.00 | 50,855,871.18 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | - | 45,902.77 |
| 35450 | Барилгын засварын материал | | - | 896,500.00 |
| 35460 | Хүнсний материал | | 676,200.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 38,950,000.00 | 132,182,418.71 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **3,604,619,792.74** | **9,753,144,847.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | **3,604,619,792.74** | **9,753,144,847.79** |
| **392** | **Биет хөрөнгө** | | **3,604,619,792.74** | **9,370,032,264.56** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 3,246,197,453.00 | 8,983,655,620.16 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (4,508,607.57) | (362,120,184.75) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 103,212,810.00 | 575,484,996.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (3,583,761.24) | (213,996,429.33) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 231,471,966.85 | 478,893,373.52 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (3,295,409.51) | (147,902,665.89) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 35,961,554.02 | 43,348,602.11 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (836,212.81) | (7,099,437.26) |
| 39217 | Ном | | - | 19,768,389.09 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | **-** | **383,112,583.23** |
| 39301 | Программ хангамж | | - | 511,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | - | (468,416.77) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | - | 383,070,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | | **3,931,364,426.81** | **10,799,287,761.60** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **30,666,156.34** | **142,289,173.09** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **30,666,156.34** | **142,289,173.09** |
| **413** | **Өглөг** | | **30,666,156.34** | **142,289,173.09** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 172,736.34 | 55,507.37 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 16,935,360.00 | 99,096,936.86 |
| 41360 | Бусад өглөг | | 13,558,060.00 | 43,136,728.86 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 13,558,060.00 | 42,784,288.86 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | | - | 352,440.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **3,900,698,270.47** | **10,656,998,588.51** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **3,900,698,270.47** | **10,656,998,588.51** |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | **3,900,698,270.47** | **10,656,998,588.51** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | - | 3,914,256,330.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 3,900,698,270.47 | 6,742,742,258.04 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | | **3,931,364,426.81** | **10,799,287,761.60** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **2** | **4,857,111,173.87** | **10,300,607,058.08** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **3,636,082,973.87** | **10,300,607,058.08** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | **3,636,082,973.87** | **6,489,455,270.32** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | | 900,000.00 | 12,271,420.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | - | 12,271,420.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 900,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – үндсэн хөрөнгө | | 3,606,782,973.87 | 6,320,618,084.17 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 28,400,000.00 | 156,565,766.15 |
| **122** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | | **-** | **3,811,151,787.76** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | - | 3,644,842,800.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | - | 166,308,987.76 |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | - | 166,308,987.76 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **1,221,028,200.00** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | **822,543,200.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 822,543,200.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | **398,485,000.00** | **-** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 398,485,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (2)** | **3** | **956,275,403.41** | **3,496,429,251.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **956,275,403.41** | **3,496,429,251.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **941,507,214.45** | **3,312,089,749.92** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **380,298,666.43** | **1,848,731,252.90** |
| 210101 | Үндсэн цалин | | 261,346,643.97 | 1,265,379,334.66 |
| 210102 | Нэмэгдэл | | 117,132,022.46 | 564,821,498.36 |
| 210104 | Урамшуулал | | 1,820,000.00 | 18,530,419.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **44,782,676.04** | **215,774,056.96** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 30,324,567.58 | 146,638,905.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 3,731,173.64 | 18,511,168.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 1,970,287.97 | 9,560,411.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 1,716,036.29 | 8,212,694.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 7,040,610.56 | 32,850,877.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **324,956,811.04** | **793,981,675.20** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 10,080,437.62 | 37,590,509.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 305,540,420.42 | 725,895,073.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 9,335,953.00 | 30,496,093.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **18,074,680.00** | **1,355,110.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 7,209,200.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 2,946,570.00 | 1,355,110.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 7,918,910.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | | **68,761,417.50** | **91,949,899.49** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 269,350.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | | 68,492,067.50 | 91,949,899.49 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **72,318,060.00** | **28,849,640.00** |
| 210604 | Урсгал засвар | | 72,318,060.00 | 28,849,640.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **7,652,562.30** | **35,443,935.85** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | - | 6,285,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 7,652,562.30 | 29,158,735.85 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **24,662,341.14** | **296,004,179.52** |
| 210901 | Бараа ажил үйлчилгээний бусад зардал | | 11,725,850.00 | 67,841,090.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 700,000.00 | 15,830,260.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 12,236,491.14 | 212,332,829.52 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **14,768,188.96** | **184,339,501.66** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | **-** | **1,654,163.66** |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | - | 1,654,163.66 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | - | 1,654,163.66 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | - | 1,654,163.66 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **-** | **182,685,338.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | - | 182,685,338.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | **14,768,188.96** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 14,768,188.96 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4** | **3,900,835,770.46** | **6,804,177,806.50** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **137,499.99** | **61,435,548.46** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | | 137,499.99 | 61,435,548.46 |
| **7** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (7)=(4)-(5)** | | **(137,499.99)** | **(61,435,548.46)** |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(7)** | **6** | **3,900,698,270.47** | **6,742,742,258.04** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,221,928,200.00** | **3,823,423,207.76** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **900,000.00** | **3,823,423,207.76** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **900,000.00** | **178,580,407.76** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 900,000.00 | 178,580,407.76 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 12,271,420.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 900,000.00 | - |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | - | 166,308,987.76 |
| **122** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **-** | **3,644,842,800.00** |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 3,644,842,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,221,028,200.00** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **822,543,200.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 822,543,200.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **398,485,000.00** | **-** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 398,485,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)** | **929,233,972.27** | **3,212,176,380.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **929,233,972.27** | **3,212,176,380.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **879,468,123.31** | **3,023,861,017.05** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **380,298,666.43** | **1,848,731,252.90** |
| 210101 | Үндсэн цалин | 261,346,643.97 | 1,262,656,875.58 |
| 210102 | Нэмэгдэл | 117,132,022.46 | 567,543,957.44 |
| 210104 | Урамшуулал | 1,820,000.00 | 18,530,419.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **44,782,676.04** | **215,774,056.96** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,324,567.58 | 146,638,905.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,731,173.64 | 18,511,168.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,970,287.97 | 9,560,411.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,716,036.29 | 8,212,694.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,040,610.56 | 32,850,877.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **313,856,811.04** | **770,454,436.34** |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,080,437.62 | 37,590,509.00 |
| 210302 | Түлш, халаалт | 294,440,420.42 | 651,267,834.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,335,953.00 | 81,596,093.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **33,447,807.50** | **86,532,195.00** |
| 210502 | Хоол, хүнс | 33,447,807.50 | 86,532,195.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **69,860,000.00** | **15,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 69,860,000.00 | 15,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **16,921,562.30** | **35,863,935.85** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 6,285,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,921,562.30 | 29,578,735.85 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,300,600.00** | **51,505,140.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,682,900.00 | 38,192,990.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,617,700.00 | 13,312,150.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **49,765,848.96** | **188,315,363.66** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **1,654,163.66** |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 1,654,163.66 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 1,654,163.66 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 1,654,163.66 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **34,997,660.00** | **186,661,200.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 34,997,660.00 | 186,661,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **14,768,188.96** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,768,188.96 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **292,694,227.73** | **611,246,827.05** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **10,210,810.00** | **40,240,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,210,810.00** | **40,240,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **10,210,810.00** | **40,240,800.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,210,810.00 | 40,240,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(10,210,810.00)** | **(40,240,800.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **282,483,417.73** | **571,006,027.05** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **282,483,417.73** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **282,483,417.73** | **853,489,444.78** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** |
| Тайлант үеийн үр дүн | 3,900,698,270.47 | 3,900,698,270.47 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,900,698,270.47** | **3,900,698,270.47** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 13,558,060.00 | 13,558,060.00 |
| Тайлант үеийн үр дүн | 6,742,742,258.04 | 6,742,742,258.04 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,656,998,588.51** | **10,656,998,588.51** |

## 2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **2,942,950,900.00** | **2,870,005,620.00** | **(72,945,280.00)** | **97.5** |
| **12** | **Татварын бус орлого** | **2,942,950,900.00** | **2,870,005,620.00** | **(72,945,280.00)** | **97.5** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **12,900,400.00** | **12,271,420.00** | **(628,980.00)** | **95.1** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 12,050,400.00 | 12,271,420.00 | 221,020.00 | 101.8 |
| 1120010 | Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/ | 850,000.00 | - | (850,000.00) | - |
| **122** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **2,930,050,500.00** | **2,857,734,200.00** | **(72,316,300.00)** | **97.5** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 2,930,050,500.00 | 2,857,734,200.00 | (72,316,300.00) | 97.5 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,225,712,000.00** | **2,465,308,580.71** | **(760,403,419.29)** | **76.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,225,712,000.00** | **2,465,308,580.71** | **(760,403,419.29)** | **76.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,012,814,100.00** | **2,278,647,380.71** | **(734,166,719.29)** | **75.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,456,984,800.00** | **1,848,731,252.90** | **(608,253,547.10)** | **75.2** |
| 210101 | Үндсэн цалин | 1,572,399,100.00 | 1,262,656,875.58 | (309,742,224.42) | 80.3 |
| 210102 | Нэмэгдэл | 866,426,200.00 | 567,543,957.44 | (298,882,242.56) | 65.5 |
| 210104 | Урамшуулал | 18,159,500.00 | 18,530,419.88 | 370,919.88 | 102.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **307,387,600.00** | **215,774,056.96** | **(91,613,543.04)** | **70.2** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 209,023,200.00 | 146,638,905.56 | (62,384,294.44) | 70.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 24,591,100.00 | 18,511,168.25 | (6,079,931.75) | 75.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,295,500.00 | 9,560,411.28 | (2,735,088.72) | 77.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,295,500.00 | 8,212,694.39 | (4,082,805.61) | 66.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 49,182,300.00 | 32,850,877.48 | (16,331,422.52) | 66.8 |
| **2105** | **Нормативт зардал** | **87,626,000.00** | **86,532,195.00** | **(1,093,805.00)** | **98.8** |
| 210502 | Хоол, хүнс | 87,626,000.00 | 86,532,195.00 | (1,093,805.00) | 98.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **45,465,400.00** | **40,824,935.85** | **(4,640,464.15)** | **89.8** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн болон нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,450,400.00 | 6,285,200.00 | (2,165,200.00) | 74.4 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 37,015,000.00 | 34,539,735.85 | (2,475,264.15) | 93.3 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **115,350,300.00** | **86,784,940.00** | **(28,565,360.00)** | **75.2** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 102,019,900.00 | 73,472,790.00 | (28,547,110.00) | 72.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,330,400.00 | 13,312,150.00 | (18,250.00) | 99.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **212,897,900.00** | **186,661,200.00** | **(26,236,700.00)** | **87.7** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **212,897,900.00** | **186,661,200.00** | **(26,236,700.00)** | **87.7** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 212,897,900.00 | 186,661,200.00 | (26,236,700.00) | 87.7 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **(282,761,100.00)** | **404,697,039.29** | **-** | **-** |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **282,761,100.00** | **(404,697,039.29)** | **-** | **-** |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **282,483,417.73** | **-** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **853,489,444.78** | **-** | **-** |

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **787,108,600.00** | **785,454,436.34** | **(1,654,163.66)** | **99.79** |
| **12** | **Татварын бус орлого** | **787,108,600.00** | **785,454,436.34** | **(1,654,163.66)** | **99.79** |
| **122** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **787,108,600.00** | **785,454,436.34** | **(1,654,163.66)** | **99.79** |
| 122005 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 787,108,600.00 | 785,454,436.34 | (1,654,163.66) | 99.79 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **787,108,600.00** | **785,454,436.34** | **(1,654,163.66)** | **99.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **787,108,600.00** | **785,454,436.34** | **(1,654,163.66)** | **99.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **787,108,600.00** | **785,454,436.34** | **(1,654,163.66)** | **99.79** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **772,108,600.00** | **770,454,436.34** | **(1,654,163.66)** | **99.79** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 39,244,600.00 | 37,590,509.00 | (1,654,091.00) | 95.79 |
| 210302 | Түлш, халаалт | 651,267,900.00 | 651,267,834.34 | (65.66) | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 81,596,100.00 | 81,596,093.00 | (7.00) | 100.00 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **15,000,000.00** | **15,000,000.00** | **-** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 15,000,000.00 | 15,000,000.00 | - | 100.00 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-** | **-** | **-** | **-** |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нийт 1,721,171.5 мянган төгрөгийн 4 алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хуучин 5 дугаар сургуулийн өмнөх оны аудитлагдсан тайлангийн эцсийн үлдэгдэл шинэ гуравдугаар сургуулийн балансын эхний үлдэгдлүүдэд нэгтгэгдээгүй байна. Нийт хөрөнгийг орлого авахдаа бодит үнээр хүлээн зөвшөөрөөгүй байна. | 1 | 1,410,506.5 | | | 1 | 1,410,506.5 | 1 | 1,410,506.5 | | | | |
| Хуучин Спорт цогцолбор сургуулийн өмнөх оны аудитлагдсан тайлангийн машин тоног төхөөрөмж дансны эцсийн үлдэгдэлтэй гуравдугаар сургуулийн балансын эхний үлдэгдлүүд тохирохгүй байна. | 1 | 815.0 | | | 1 | 815.0 | 1 | 815.0 | | | | |
| Балансад цэвэр бохир усны 51,100.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл хасах тэмдэгтэйгээр тайлагнасан байна. | 1 | 51,100.0 | | | 1 | 51,100.0 | 1 | 51,100.0 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд Улсын төсвийн санхүүжилтийг улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлгээр зардалд бичиж, зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 258,750.0 | | | 1 | 258,750.0 | 1 | 258,750.0 | | | | |
| **Дүн** | **4** | **1,721,171.5** | | | **4** | **1,721,171.5** | **4** | **1,721,171.5** | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

**3.2** Аудитаар нийт 1,182,449.3 мянган төгрөгийн буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй 10 зөрчил[2] илэрсэнд 189,101.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 3 төлбөрийн акт, 834,963.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 158,384.4 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Татан буугдсан 5 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 187,067.0 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд татан төвлөрүүлээгүй байна. | 1 | 187,067.0 | 1 | 187,067.0 | | | | - | | | | |
| Авлагын дансанд бүртгэлтэй Есөн хэлхээ ХХК-иас авах 550.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна. | 1 | 550.0 | 1 | 550.0 | | | | | | | | |
| Татан буугдсан 5 дугаар сургуулийн НДШ-ийн илүү төлөлт хийсэн 1,484.7 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй, тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна. | 1 | 1,484.8 | 1 | 1,484.8 | | | | | | | | |
| Спортын төрөлжсөн сургуулийн 1-8 дугаар сарын цалингийн холбогдолтой бүх анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтуудыг шалгагдагч этгээд аудитад ирүүлээгүйгээс баримт материалтай танилцах мэдээлэл авах боломжоор хангаагүй зөрчил байна. | 1 | 818,482.9 | | | 1 | 818,482.9 | | | | | | |
| Ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн захирлын 2025 оны "Өмч хүлээн | 1 | 16,480.2 | | | 1 | 16,480.2 | | | | | | |

[2] Хүнин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл/

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| авах, хамгаалах ажлын хэсэг байгуулах тухай" А/12 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хөрөнгийн тооллогоор нийт 16,480.2 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан боловч тайланд тусгаагүй байна. | | | | | | | | | | | | | |
| Үдийн цай, хүнсний материалын захиалгын хуудас, зарцуулалтын бүртгэл, тайлан баталгаажуулалтгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна. | 1 | 129,734.4 | | | | | 1 | 129,734.4 | | | | | |
| Сургуулийн бараа материалын дансанд бүртгэлтэй хөшигний тоо, үнэ тохирохгүй байна. | 1 | 19,800.0 | | | | | 1 | 19,800.0 | | | | | |
| Батлагдсан бүтэц орон тооны албан тушаалын жагсаалтад тусгаагүй ажлын байранд 1 ажилтныг ажиллуулж, 7,651.5 мянган төгрөгийн цалин, 1,198.5 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх шимтгэлийн зардал гаргасан байна. | 1 | 8,850.0 | | | | | 1 | 8,850.2 | | | | | |
| **Дүн** | **8** | **1,182,449.3** | **3** | **189,101.8** | **2** | **834,963.1** | **3** | **158,384.4** | | | | | |

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар 2 зөрчил илэрч, зөрчилд 2 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** */мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ***Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил*** | | | | | | | | |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нэгдсэн цахим хуудсанд байгууллагын нэршил буруу, тухай бүр байршуулах 108 мэдээлэл, сар бүр байршуулах 48 мэдээлэл, хагас жилээр байршуулах 4 мэдээлэл, жилд байршуулах 11 мэдээлэл, нийт 171 мэдээллээс 135 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлсэн, 24 мэдээллийг хугацаа хоцроож, 10 мэдээлэл байршуулаагүй, 25 мэдээллийг буруу мэдээлсэн байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | | | | | **1** | **-** |
| ***Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил*** | | | | | | | | |
| Төрийн алба хаах насны хязгаар давсан ажилтныг ажиллуулж, хөдөлмөрийн гэрээгээ нийт хөлсөөр тохирч гэрээндээ тусгаагүй зөрчил байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | | | | | **1** | **-** |
| **Нийт дүн** | **2** | **-** | | | | | **2** | **-** |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn